



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/79

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дэх заалт, 14.4 дэх хэсэг, Засгийн газрын 2026 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэр, Засгийн газрын 2021 оны 5 дугаар тогтоолын 3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Болзол батлах тухай" 87,88 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/49 дүгээр захирамж, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын аврга малчин, аймгийн хошой аварга, аварга малчин, хадланч, тариаланчийн урамшуулалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Тус ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулан, шаардагдах 19,040,000 (Арван есөн сая дөчин мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын оны
... дугаар сарын ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт



ХӨРӨНГИЙН ЗАДАРГАА

№	Зардлын зүйл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Дуран	112	170,000	19,040,000
	Нийт дүн			19,040,000

_ оОо _